



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДУА-2022/43/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Мандалговь хот

2022 он

Аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: Р.Мөнхтогтох

Утас: 70592439

Цахим хаяг: Munkhtogtokhr@audit.gov.mn

Аудитын менежер: Х.Наранцацрал

Утас: 70592225

Цахим хаяг: Narantsatsralkh@audit.gov.mn

Ахлах аудитор: Т.Батсайхан

Утас: 70593113

Цахим хаяг: Batsaikhant@audit.gov.mn

Аудитор: Д.Должинсүрэн

Утас: 70593113

Цахим хаяг: Doljinsurend@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

.....	0
1.Аудитын санал дүгнэлт.....	2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	5
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	6
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
3. Аудитын тайлан.....	13
3.1 Ерөнхий зүйл.....	13
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	13
3.4 Материаллаг байдал.....	14
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	14
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	15
3.6.1 Төсвийн төлөвлөлт.....	15
3.6.2 Төсвийн гүйцэтгэл.....	15
3.6.3 Нэмэлт төсөв.....	15
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	16
3.8 Аудитын гол асуудал.....	16
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	16
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	16
3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд.....	16
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	17
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
4. Аудитын илрүүлэлт.....	17
4.1 Залруулсан алдаа.....	17
4.2 Төлбөрийн акт.....	17
4.3 Албан шаардлага.....	17
4.4 Аудитын зөвлөмж.....	18
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	0

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗЗББУТ	Зах зээл ба бэлчээрийн удирдлагын төсөл
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуучлалын яам



**ДУНДГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Нутгийн удирдлагын ордон, 7-р баг, Сайнцагаан сум
Дундговь аймаг 48090 Утас: 70592439, 70592208,
70593208, Цахим хаяг: dundgovi@audit.gov.mn

2022.02.25. № 78

танай _____ -ны № _____ -т

**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.ДОРЖБАТ ТАНАА**

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

0012029869

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Handwritten signature of P. Mönхтогтох in black ink, written over a faint rectangular stamp.

Р.МӨНХТОГТОХ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН (I)	359,218,349.76	495,526,810.91
33	АВЛАГА	121,069,631.00	239,097,310.00
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,040,500.00	3,904,600.00
33500	Бусад авлага	116,029,131.00	235,192,710.00
33510	Байгууллагаас авах авлага	55,607,819.00	137,607,819.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	60,421,312.00	97,584,891.00
35	БАРАА МАТЕРИАЛ	238,148,718.76	256,429,500.91
35100	Түүхий эд материал	108,480.00	108,480.00
35110	Тусгай зориулалттай материал	108,480.00	108,480.00
35400	Хангамжийн материал	238,040,238.76	256,321,020.91
35410	Бичиг хэргийн материал	5,806,225.00	4,823,845.00
35420	Аж ахуйн материал	220,962,213.76	246,420,335.91
35430	Сэлбэг хэрэгсэл	2,923,800.00	1,875,000.00
35440	Түлш, шатах тослох материал	7,258,000.00	2,606,840.00
35460	Хүнсний материал	1,090,000.00	595,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН (II)	14,068,820,595.79	14,376,290,170.97
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	14,068,820,595.79	14,376,290,170.97
39200	Биет хөрөнгө	8,444,936,595.79	8,752,406,170.97
39201	Барилга, байгууламж, орон сууц	8,161,839,287.07	8,611,990,390.07
39202	Хуримтлагдсан элэгдэл - Барилга	(354,748,454.78)	(581,414,615.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	651,050,000.00	561,050,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл - Тээврийн хэрэгсэл	(370,986,110.88)	(352,494,444.12)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	783,984,119.91	854,793,637.08
39206	Хуримтлагдсан элэгдэл - Тоног төхөөрөмж	(685,014,199.78)	(694,398,702.61)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	379,348,676.79	454,190,444.74
39208	Хуримтлагдсан элэгдэл - Тавилга	(190,420,091.22)	(217,461,823.25)
39214	Бусад үндсэн хөрөнгө	115,908,977.00	163,528,220.00
39215	Хуримтлагдсан элэгдэл - Бусад үндсэн хөрөнгө	(46,025,608.32)	(47,376,935.88)
39300	Биет бус хөрөнгө	5,623,884,000.00	5,623,884,000.00
39301	Програм хангамж	89,371,100.00	89,371,100.00
39302	Хуримтлагдсан элэгдэл - Програм хангамж	(89,371,100.00)	(89,371,100.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	5,623,884,000.00	5,623,884,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	14,428,038,945.55	14,871,816,981.88
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР (IV)	1,268,000.00	209,463,748.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,268,000.00	209,463,748.00
41300	Өглөг	1,268,000.00	209,463,748.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	1,268,000.00	140,460,381.00
413210	Урсгал засварын зардлын тооцоо		
413213	Бусад зардлын өглөг	1,268,000.00	140,460,381.00
41360	Бусад өглөг		69,003,367.00
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
41361	Байгууллагад төлөх өглөг		69,003,367.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (V)	14,426,770,945.55	14,662,353,233.88
51	Засгийн газрын хувь оролцоо	14,426,770,945.55	14,662,353,233.88
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,563,985,972.28	7,563,985,972.28
51200	Хуримтлагдсан үр дүн	4,040,449,223.06	4,276,031,511.39
51210	Өмнөх үеийн үр дүн	1,365,017,717.72	3,966,243,582.06
51220	Тайлант үеийн үр дүн	2,675,431,505.34	309,787,929.33
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,822,335,750.21	2,822,335,750.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	14,428,038,945.55	14,871,816,981.88

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,212,406,192.17	4,435,060,893.21
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,071,025,961.17	703,288,901.56
1200	Нийтлэг татварын бус орлого	3,071,025,961.17	703,288,901.56
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,482,630.00	163,349,371.19
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого		
		236,115.00	531,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	7,246,515.00	7,854,500.19
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	-	154,963,871.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	3,050,714,621.76	489,335,765.37
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Материал	12,828,709.41	50,603,765.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,141,380,231.00	3,731,771,991.65
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,173,329,431.00	925,064,291.65
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,635,740.00	21,579,555.00
131103	ЗГНХ,ЗДНХхөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	34,430,300.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	1,105,993,691.00	798,435,770.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,269,700.00	105,048,966.65
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,968,050,800.00	2,806,707,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,968,050,800.00	2,806,707,700.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II)	3,473,809,497.13	4,121,313,672.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,594,222,754.13	3,445,167,025.93
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,328,460,444.13	2,726,500,378.73
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	887,035,177.00	943,210,558.54
210101	Үндсэн цалин	372,688,320.00	499,510,620.54
210102	Нэмэгдэл	219,469,470.00	184,688,141.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	51,846,038.00	57,458,430.00
210104	Урамшуулал	48,180,004.00	53,057,246.00
210105	Гэрээт ажлын цалин	194,851,345.00	148,496,121.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,487,608.00	115,171,864.75
210201	Тэтгэврийн даатгал	70,636,773.00	79,717,944.45
210202	Тэтгэмжийн даатгал	8,313,357.00	8,882,299.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,559,964.00	7,019,998.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,511,762.00	1,667,850.57
210205	Эрүүл мэндийн даатгал	16,465,752.00	17,883,771.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	201,607,050.00	218,791,400.00
210301	Гэрэл, цахилгаан	19,235,964.00	19,574,881.00
210302	Түлш, халаалт	174,615,100.00	189,849,344.00
210303	Цэвэр, бохир ус	7,755,986.00	9,367,175.00
2104	Хангамж, бараа материалын зардал	122,944,129.00	125,459,035.45
210401	Бичиг хэрэг	12,681,600.00	9,528,550.00
210402	Тээвэр, шатахуун	74,598,130.00	43,313,849.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,240,473.00	12,664,787.00
210404	Ном, хэвлэл	-	160,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	147,456.00	147,456.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,276,470.00	33,732,562.85
210408	Бараа материал актласны зардал	-	25,471,630.00
210409	Бараа материал шилжүүлсний зардал	-	440,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	50,664,780.00	82,715,957.75

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210604	Урсгал засвар	50,664,780.00	82,715,957.75
2107	Томилолт, зочны зардал	92,054,219.00	53,762,966.00
210702	Дотоод албан томилолт	39,243,000.00	25,703,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	52,811,219.00	28,059,966.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,573,694.00	10,360,215.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,934,094.00	-
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,900,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	6,831,700.00	5,967,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	850,000.00	377,190.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	242,000.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,337,200.00
210807	Газрын төлбөр	815,900.00	535,625.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	831,093,787.13	1,177,028,381.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	434,735,552.00	778,063,411.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	15,131,165.00	8,764,200.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдол	381,227,070.13	390,200,770.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	265,762,310.00	718,666,647.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,571,565.00	176,326,720.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	9,470,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	-	5,148,600.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	85,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,447,100.00	15,830,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,124,465.00	145,792,520.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	174,190,745.00	542,339,927.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	174,190,745.00	542,339,927.20
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	879,586,743.00	676,146,647.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	879,586,743.00	676,146,647.00
223001	Бусад хөрөнгө	879,586,743.00	676,146,647.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II)	2,738,596,695.04	313,747,220.28
5	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН (V)	63,165,189.70	3,959,290.95
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ	63,165,189.70	3,959,290.95
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	63,165,189.70	3,959,290.95
6	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI=III+IV-V)	2,675,431,505.34	309,787,929.33

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн хөрөнгө оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,563,985,972.28	2,822,335,750.21	1,365,195,016.09	11,751,516,738.58
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(177,298.37)	(177,298.37)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,563,985,972.28	2,822,335,750.21	1,365,017,717.72	11,751,339,440.21
9	Тайлант үеийн үр дүн			2,675,431,505.34	2,675,431,505.34
10	2020 оны 12-р сарын 31-	7,563,985,972.28	2,822,335,750.21	4,040,449,223.06	14,426,770,945.55

	нээрх үлдэгдэл				
11	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,563,985,972.28	2,822,335,750.21	4,040,449,223.06	14,426,770,945.55
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			(74,205,641.00)	(74,205,641.00)
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,563,985,972.28	2,822,335,750.21	3,966,243,582.06	14,352,565,304.55
19	Тайлант үеийн үр дүн			309,787,929.33	309,787,929.33
20	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,563,985,972.28	2,822,335,750.21	4,276,031,511.39	14,662,353,233.88

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	3,148,836,361.00	3,735,993,167.84
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	7,456,130.00	9,423,450.19
1200	Нийтлэг татварын бус орлого	7,456,130.00	9,423,450.19
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	7,456,130.00	9,423,450.19
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлого	236,115.00	531,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлого	7,220,015.00	8,892,450.19
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,141,380,231.00	3,726,569,717.65
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,173,329,431.00	919,862,017.65
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	12,635,740.00	21,579,555.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан	34,430,300.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	1,105,993,691.00	793,233,496.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	20,269,700.00	105,048,966.65
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,968,050,800.00	2,806,707,700.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,968,050,800.00	2,806,707,700.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	2,231,033,418.00	3,141,708,901.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,231,033,418.00	3,141,708,901.84
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,965,271,108.00	2,423,042,254.64
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	892,378,383.00	947,562,581.54
210101	Үндсэн цалин	378,031,526.00	503,862,643.54
210102	Нэмэгдэл	219,469,470.00	184,688,141.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	51,846,038.00	57,458,430.00
210104	Урамшуулал	48,180,004.00	53,057,246.00
210105	Гэрээт ажлын цалин	194,851,345.00	148,496,121.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	104,386,308.00	115,475,820.75
210201	Тэтгэврийн даатгал	71,427,038.00	79,992,246.45
210202	Тэтгэмжийн даатгал	8,421,792.00	8,911,953.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,559,964.00	7,019,998.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,511,762.00	1,667,850.57
210205	Эрүүл мэндийн даатгал	16,465,752.00	17,883,771.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	201,607,050.00	218,791,400.00

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

210301	Гэрэл, цахилгаан	19,235,964.00	19,574,881.00
210302	Түлш, халаалт	174,615,100.00	189,849,344.00
210303	Цэвэр, бохир ус	7,755,986.00	9,367,175.00
2104	Хангамж, бараа материалын зардал	142,752,279.00	84,720,988.60
210401	Бичиг хэрэг	11,535,650.00	8,878,150.00
210402	Тээвэр, шатахуун	77,959,790.00	37,323,489.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,240,473.00	12,664,787.00
210404	Ном, хэвлэл		670,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	147,456.00	147,456.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	40,868,910.00	25,036,906.00
2105	Нормативт зардал	2,820,000.00	385,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	2,820,000.00	385,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	55,460,360.00	84,355,227.75
210604	Урсгал засвар	55,460,360.00	84,355,227.75
2107	Томилолт, зочны зардал	89,720,039.00	51,926,010.00
210702	Дотоод албан томилолт	38,175,000.00	25,703,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	51,545,039.00	26,223,010.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,735,264.00	10,360,215.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	25,095,664.00	
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,900,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	6,831,700.00	5,967,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	850,000.00	377,190.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	242,000.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,000,000.00	3,337,200.00
210807	Газрын төлбөр	815,900.00	535,625.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	437,411,425.00	909,465,011.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	421,834,580.00	900,700,811.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	15,576,845.00	8,764,200.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	265,762,310.00	718,666,647.20
2132	Бусад урсгал шилжүүлэг	91,571,565.00	176,326,720.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж		9,470,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал		5,148,600.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт		85,000.00
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	58,447,100.00	15,830,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	33,124,465.00	145,792,520.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	174,190,745.00	542,339,927.20
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	174,190,745.00	542,339,927.20
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III=I-II)	917,802,943.00	594,284,266.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)		
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	917,802,943.00	594,284,266.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	917,802,943.00	594,284,266.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	917,802,943.00	594,284,266.00
223001	Бусад хөрөнгө	879,586,743.00	536,954,266.00
223004	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	38,216,200.00	57,330,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI=IV-V)	(917,802,943.00)	(594,284,266.00)
9	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		
10	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН		

7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VII)		
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII=III+VI+VII)		
14	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
15	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,615,899,200.00	1,603,944,624.25
12	Татварын бус орлого	1,615,899,200.00	1,603,944,624.25
12000	Нийтлэг татварын бус орлого		531,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/		531,000.00
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	7,000,000.00	8,892,450.19
12200	Тусламжийн орлого	1,608,899,200.00	1,594,521,174.06
122005	Төсвөөс санхүүжих	1,608,899,200.00	1,594,521,174.06
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,615,899,200.00	1,603,944,624.25
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,615,899,200.00	1,603,944,624.25
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,615,899,200.00	1,603,944,624.25
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	936,202,100.00	933,032,028.15
210101	Үндсэн цалин	444,733,900.00	492,492,691.15
210102	Нэмэгдэл	221,518,100.00	183,772,540.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	52,552,500.00	55,213,430.00
210104	Урамшуулал	56,338,500.00	53,057,246.00
210105	Гэрээт ажлын хөлс	161,059,100.00	148,496,121.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	115,966,100.00	113,627,141.75
210201	Тэтгэврийн даатгал	80,227,500.00	78,684,520.45
210202	Тэтгэмжийн даатгал	8,861,900.00	8,766,369.51
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,985,100.00	6,903,529.26
210204	Ажилгүйдлийн даатгал	1,823,600.00	1,621,651.57
210205	Эрүүл мэндийн даатгал	18,068,000.00	17,651,070.96
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	218,791,400.00	218,791,400.00
210301	Гэрэл, цахилгаан	19,575,500.00	19,574,881.00
210302	Түлш, халаалт	189,853,500.00	189,849,344.00
210303	Цэвэр, бохир ус	9,362,400.00	9,367,175.00
2104	Хангамж, бараа материалын зардал	82,824,700.00	82,774,988.60
210401	Бичиг хэрэг	8,245,500.00	8,628,150.00
210402	Тээвэр, шатахуун	37,393,400.00	37,323,489.60
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	12,746,100.00	12,664,787.00
210404	Ном, хэвлэл	670,200.00	670,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	147,500.00	147,456.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	23,622,000.00	23,340,906.00
2105	Нормативт зардал	385,000.00	385,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	385,000.00	385,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	141,204,400.00	138,272,227.75
210601	Багаж, техник хэрэгсэл	44,500,000.00	44,500,000.00
210602	Тавилга	9,930,000.00	9,930,000.00

210604	Урсгал засвар	86,774,400.00	83,842,227.75
2107	Томилолт, зочны зардал	53,421,800.00	51,767,010.00
210702	Дотоод албан томилолт	26,500,200.00	25,544,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	26,921,600.00	26,223,010.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамж	10,360,300.00	10,360,215.00
210803	Даатгалын үйлчилгээ	5,967,200.00	5,967,200.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	377,200.00	377,190.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	143,000.00	143,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	3,337,200.00	3,337,200.00
210807	Газрын төлбөр	535,700.00	535,625.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	56,743,400.00	54,934,613.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	52,120,600.00	50,311,813.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	4,622,800.00	4,622,800.00
80305	Биеийн тамирын уралдаан, тэмцээн	188,700.00	188,650.00
12	Татварын бус орлого	188,700.00	188,650.00
12200	Тусламжийн орлого	188,700.00	188,650.00
122005	Төсвөөс санхүүжих	188,700.00	188,650.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	188,700.00	188,650.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	188,700.00	188,650.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	188,700.00	188,650.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	188,700.00	188,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	188,700.00	188,650.00
80714	Ахмад настнуудад үзүүлэх хөнгөлөлт	9,470,000.00	9,470,000.00
12	Татварын бус орлого	9,470,000.00	9,470,000.00
12200	Тусламжийн орлого	9,470,000.00	9,470,000.00
122005	Төсвөөс санхүүжих	9,470,000.00	9,470,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	9,470,000.00	9,470,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	9,470,000.00	9,470,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	9,470,000.00	9,470,000.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	9,470,000.00	9,470,000.00
80801	Нөхөн олговор	5,148,600.00	5,148,600.00
12	Татварын бус орлого	5,148,600.00	5,148,600.00
12200	Тусламжийн орлого	5,148,600.00	5,148,600.00
122005	Төсвөөс санхүүжих	5,148,600.00	5,148,600.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	5,148,600.00	5,148,600.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,148,600.00	5,148,600.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,148,600.00	5,148,600.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	5,148,600.00	5,148,600.00
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	130,915,600.00	130,408,120.00
12	Татварын бус орлого	130,915,600.00	130,408,120.00
12200	Тусламжийн орлого	130,915,600.00	130,408,120.00
122005	Төсвөөс санхүүжих	130,915,600.00	130,408,120.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	130,915,600.00	130,408,120.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	130,915,600.00	130,408,120.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	130,915,600.00	130,408,120.00
213206	Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	85,000.00	85,000.00

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	15,830,600.00	15,830,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	115,000,000.00	114,492,520.00
80918	Бусад	-	-
81102	Орон нутгийн нөөц хөрөнгө	1,042,085,600.00	834,943,093.00
12	Татварын бус орлого	1,042,085,600.00	834,943,093.00
12200	Тусламжийн орлого	1,042,085,600.00	834,943,093.00
122005	Төсвөөс санхүүжих	1,042,085,600.00	834,943,093.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,042,085,600.00	834,943,093.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,042,085,600.00	834,943,093.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,042,085,600.00	834,943,093.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,042,085,600.00	834,943,093.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1,042,085,600.00	834,943,093.00
82310	Гамшигаас сэргийлэх сургалт, сурталчилгаа	10,000,000.00	10,000,000.00
12	Татварын бус орлого	10,000,000.00	10,000,000.00
12200	Тусламжийн орлого	10,000,000.00	10,000,000.00
122005	Төсвөөс санхүүжих	10,000,000.00	10,000,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,000,000.00	10,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	10,000,000.00	10,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,000,000.00	10,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	10,000,000.00	10,000,000.00
	Байгууллагын нийт ажилчид	64	64
	Удирдах	3	3
	Гүйцэтгэх	37	37
	Үйлчлэх	24	24
	Гэрээт	0	0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (I)	919,862,017.65
21	УРСГАЛ ЗАРДАЛ	382,907,751.65
210	БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	31,295,887.39
2101	Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	14,530,553.39
210101	Үндсэн цалин	11,369,952.39
210102	Нэмэгдэл	915,601.00
210103	Унаа хоолны Хөнгөлөлт	2,245,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	1,848,679.00
210201	Тэтгэврийн даатгал	1,307,726.00
210202	Тэтгэмжийн даатгал	145,584.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	116,469.00
210204	Ажилгүйдлийн даатгал	46,199.00
210205	Эрүүл мэндийн даатгал	232,701.00
2104	Хангамж, бараа материалын зардал	1,946,000.00
210401	Бичиг хэрэг	250,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,696,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,413,000.00
210602	Тавилга	2,900,000.00
210604	Урсгал засвар	513,000.00

2107	Томилолт, зочны зардал	159,000.00
210702	Дотоод албан томилолт	159,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,398,655.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,257,255.00
210902	Хичээл, үйлдвэрлэлийн дадлага хийх	4,141,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	351,611,864.26
2132	Бусад урсгал шилжүүлэг	31,300,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	31,300,000.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	320,311,864.26
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	320,311,864.26
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	536,954,266.00
223	БУСАД ХӨРӨНГӨ	536,954,266.00
223001	Бусад хөрөнгө	536,954,266.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР (II)	919,862,017.65
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	919,862,017.65
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	919,862,017.65
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	21,579,555.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан х	793,233,496.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,048,966.65
III	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
12000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Д.Должинсүрэн гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Наранцацрал, газрын дарга, тэргүүлэх аудитор Р.Мөнхтогтох нар тус тус хэрэгжүүлсэн.

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дундговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 26-ний өдрийн 02/99 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар нь эрхэм зорилгоо “Төр иргэн хувийн хэвшлийн хамтын ажиллагаанд ил тод байдлыг ханган хүн амын эрүүл аюулгүй амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлж, эдийн засгийн өсөлтийг нэмэгдүүлж байгалийн тэнцвэрт байдлыг хангана” гэж тодорхойлжээ.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Санхүүгийн хяналт, аудитын албанаас 2021 оны 3 улирлын байдлаарх санхүүгийн үйл ажиллагаанд хяналт хийж, 1 зөвлөмжийг хүргүүлсэн байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд тусалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл

баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл их гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 0.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 14,461,273.0 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 72,306.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 65 хувиар буюу 46,999.1 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн шатанд төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг дахин хянаж, залруулсан 2021 оны 4 дүгээр улирлын санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 14,871,816.9 мянган төгрөгөөс 0.5 хувиар буюу 74,356.1 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлын 65 хувиар буюу 48,333.1 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Дундговь аймгийн Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 443,778.0 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс хамгийн их өөрчлөлт гарсан хөрөнгийн данс нь эргэлтийн бус хөрөнгийн данс бөгөөд 307,469.6 мянган төгрөгөөр өссөн нь нөлөөлсөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Эргэлтийн хөрөнгийн дүн (i)	359,218.3	495,526.8	136,308.5
Авлага	121,069.6	239,097.3	118,027.7
Бараа материал	238,148.7	256,429.5	18,280.8
Эргэлтийн бус хөрөнгийн дүн (ii)	14,068,820.6	14,376,290.2	307,469.6
Үндсэн хөрөнгө	14,068,820.6	14,376,290.2	307,469.6
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН (III=I+II)	14,428,038.9	14,871,817.0	443,778.0
Нийт өр төлбөр (iv)	1,268.0	209,463.7	208,195.7
Богино хугацаат өр төлбөр	1,268.0	209,463.7	208,195.7
Цэвэр хөрөнгө өмчийн дүн (v)	14,426,770.9	14,662,353.2	235,582.3
Засгийн газрын хувь оролцоо	14,426,770.9	14,662,353.2	235,582.3
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН (VI=IV+V)	14,428,038.9	14,871,817.0	443,778.0

Авлагын дансны үлдэгдэл 239,097.3 мянган төгрөг болж, өмнөх оноос 118,027.7 мянган төгрөгөөр өссөн нь байгууллагаас авах авлагын өсөлт байна.

Бараа материал дансны үлдэгдэл 256,429.5 мянган төгрөг болж, өмнөх оноос 18,280.8 мянган төгрөгөөр өссөн нь хангамжийн материалын өсөлт байна.

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансанд төсвийн хөрөнгөөр 57,330.0 мянган төгрөгийн тоног төхөөрөмж, тавилга эд хогшил худалдан авч, аймгийн орон нутгийн хөгжлийн сан болон ЗЗББУ төслөөр хийгдсэн 450,151.1 мянган төгрөгийн 2 үл хөдлөх

хөрөнгө, 194,148.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй шилжүүлэн авч, 92,868.0 мянган төгрөгийн хөрөнгийг актлан, 55,339.9 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг бусад байгууллагад шилжүүлсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 14,662,353.2 мянган төгрөг болж 443,778.0 мянган төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнөөс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,356,257.5 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,356,257.5 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 450,450.2 мянган төгрөгөөр өсгөн 2,806,707.7 мянган төгрөгөөр баталсан байна. Төсвийн өсөлт нь цар тахлын үеийн бэлэн байдлын зардлыг нэмэгдүүлсэнтэй холбоотой.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр орон нутгийн төсвөөс 2,813,707.7 мянган төгрөгийн төсөв баталсан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 2,813,707.7 мянган төгрөгийн санхүүжилт авч, төлөвлөгөөнд батлагдаагүй өөрийн орлого 2,423.4 мянган төгрөг орж, үүнээс үндсэн үйл ажиллагаанд 2,594,103.0 мянган төгрөгийг зарцуулж, 222,028.1 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,594,103.0 мянган төгрөг буюу 92.2 хувьтай байгаа нь цалин хөлс болон ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлын гүйцэтгэл буюу батлагдсан орон тооноос дутуу үйл ажиллагаагаа явуулсан мөн Засаг даргын нөөц хөрөнгийн төлөвлөгөөт зарим зардлууд хэмнэгдсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 919,862.0 мянган төгрөгийн орлого орж ирсэн бөгөөд зохих зардлын зүйлүүдэд зарцуулах эрх нээлгэж журмын дагуу зарцуулсан байна. Үүнд: Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслөөс 664,930.2 мянган төгрөг, БОАЖЯ-аас 88,589.2 мянган төгрөгийн санхүүжилт хуваарилсан байна. Мөн байгууллага, иргэдээс 21,579.6 мянган төгрөгийн хандив, Монгол даатгал ХХК-с 699.3 мянган төгрөгийн машины даатгалын төлбөр, Төрийн албаны зөвлөлөөс ерөнхий шалгалтын зардал 4,144.0 мянган төгрөг, бусад газраас 139,919.7 мянган төгрөгийг тухайн төсвийн захирагчид хуваарилан орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс үйл ажиллагааны зардалд 62,595.9 мянган төгрөгийг зарцуулж, 536,954.3 мянган төгрөгийг хөрөнгийн зардалд зарцуулан, 320,311.8 мянган төгрөгийг орон нутгийн орлогод буцаан төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд байгууллагын үндсэн хөрөнгөнд 20,590.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авснаас 15,430.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил нь ЗГ-аас баталсан төсвийн хэмнэлтийн 43 дугаар тогтоол батлагдахаас өмнө гэрээ хийж, гүйцэтгүүлсэн ажил байна.

Цар тахалтай холбоотой 21,579.6 мянган төгрөгийн хандив орж ирснээс ковид цар тахлын үед түргэвчилсэн оношлуур, халдвартай бүсэд ажиллахад хамгаалах хувцас хэрэглэл худалдан авахад зарцуулжээ.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдал байхгүй тул гол асуудал байхгүй гэж үзлээ.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь тус хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг шилэн дансны цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газар нь 2021 онд нийт 6,786,876.4 мянган төгрөгийн 165 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ил тод, бүрэн байршуулахаас 1 мэдээллийг хугацаа хоцроож, 1 мэдээллийг огт мэдээлээгүй хэрэгжилт 98 хувьтай байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол зөрчсөн 14,672.2 мянган төгрөгийн дараах зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль

тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, бусад хууль тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 162,101.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрч, аудитын явцад 7,757.1 мянган төгрөгийн алдааг залруулан, 147,682.9 мянган төгрөгт 6 албан шаардлага хүргүүлж, 6,661.1 мянган төгрөгийн 2 зөрчилд төлбөрийн акт тогтоож, хэрэгжилтийг хангуулан ажилласан байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан үндсэн хөрөнгө, бараа материалын дансанд завсрын аудитаар хяналтын тооллого хийх, тээвэр шатахууны тооцоонд давтан тооцоолол хэрэгжүүлэхээр шийдвэрлэлээ.

Мөн Дундговь аймгийн Засаг даргын Тамгын газрын төрийн жинхэнэ албан хаагч цалингийн нэмэгдэлтэй холбоотой, эргэлзээтэй асуудлыг шийдвэрлэх цаг хугацааны боломжгүй байгаа тул 2022 оны завсрын аудитаар тодруулахаар болсон.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 664,868.1 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 618,837.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 978.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт, 45,052.6 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1 зөвлөмж хүргүүлээ.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Ёслол хүндэтгэлийн өргөөний 90,592.4 мянган төгрөгийн засварын ажлыг бүртгээгүй. /Сайжруулалтаар/;
2. Шинээр баригдсан 183,912.5 мянган төгрөгийн өвс тэжээлийн саравч агуулахыг үндсэн хөрөнгөд бүртгээгүй;
3. Шинээр баригдсан 136,136.9 мянган төгрөгийн хүнсний ногооны зоорийг бүртгэлд аваагүй;
4. Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслөөр хийгдэх хөрөнгийн үлдэгдэл 69,590.6 мянган төгрөгийг АОНХС-д өгөхөөр бүртгээгүй /АОНХС/;
5. Хулд сумын ОНХС-ийн 4,500.0 мянган төгрөгийн өглөгийг бүртгээгүй;
6. Бизнес хөгжлийн төвийн барилгын үлдэгдэл 132,976.5 мянган төгрөгийн төлбөрийг өглөгөөр бүртгээгүй;
7. Аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах ажлын гүйцэтгэлийн дутуу 1,128.6 мянган төгрөгийн төлбөрийг өглөгөөр бүртгээгүй.

Шийдвэрлэсэн нь: Аудитын явцад 618,837.5 мянган төгрөгийн алдааг залруулсан.

4.2 Төлбөрийн акт

Аудитаар нийт 978.0 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоолоо. Үүнд:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч нарт хүндэтгэл үзүүлэхдээ Аймгийн ИТХ-аас баталсан бэлэг дурсгалын зүйл гардуулах зардлын нормативаас 978.0 мянган төгрөгийг илүү олгосон.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоосон.

4.3 Албан шаардлага

Аудитаар нийт 45,052.6 мянган төгрөгийн зөрчилд хугацаатай албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Аудитаар санхүүгийн тайлан дахь өндөр насжилттай 16,289.1 мянган төгрөгийн өр төлбөр, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй;
2. 14,091.2 мянган төгрөгийн бараа материалыг шууд зардлаар тайлагнаж, хяналтгүй зарцуулсан;
3. Төсвийн хэмнэлтийн талаар авах хэмжээг зөрчин 5,160.0 мянган төгрөгийг тавилга, эд хогшил худалдан авахад, 9,512.2 мянган төгрөгийг сургалт, семинар зохион байгуулахад, зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Хугацаатай албан шаардлага хүргүүлсэн.

4.4 Аудитын зөвлөмж

1. Хүний нөөцийн бодлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт:

1. Аймгийн ЗДТГ албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дэмжлэг олгохдоо, тодорхой шалгуургүй, цаашид тогтвор сууршилтай ажиллуулах талаар гэрээ байгуулалгүй дэмжлэг үзүүлсэн.

Өгсөн зөвлөмж:

Дундговь аймгийн ЗДТГ-ын “Албан хаагчдын сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-т хамрагдах албан хаагчдын шалгуурыг тодорхой болгож, тодорхой хугацаанд тогтвор суурьшилтай ажиллах талаар гэрээ байгуулж ажиллах зөвлөмж хүргүүлээ.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Д/ Д	Алдаа, зөрчлийн агуулга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1. Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Төсвийн хэмнэлтийн талаар авах хэмжээг зөрчин 5,160.0 мянган төгрөгийг тавилга, эд хогшил худалдан авахад, 9,512.2 мянган төгрөгийг сургалт, семинар зохион байгуулахад, зарцуулсан.	1	14,672.2					1	14,672.2		
	Дүн	1	14,672.2					1	14,672.2		
2. Бусад батламж мэдэгдлийн хүрээнд:											
1	Ёслол хүндэтгэлийн өргөөний засварын ажлыг сайжруулалтаар бүртгээгүй.	1	90,592.4	1	90,592.4						
2	Шинээр баригдсан өвс тэжээлийн саравч агуулахыг үндсэн хөрөнгөд бүртгээгүй.	1	183,912.5	1	183,912.5						
3	Шинээр баригдсан хүнсний ногооны зоорийг бүртгэлд аваагүй.	1	136,136.9	1	136,136.9						
4	Зах зээл ба бэлчээрийн удирдлага төслөөр хийгдэх хөрөнгийн үлдэгдэл 69,590.6 мянган төгрөгийг АОНХС-д өгөхөөр бүртгээгүй.	1	69,590.6	1	69,590.6						
5	Хулд сумын ОНХС-ийн 4,500.0 мянган төгрөгийн өглөгийг бүртгээгүй.	1	4,500.0	1	4,500.0						
6	Бизнес хөгжлийн төвийн барилгын үлдэгдэл 132,976.5 мянган төгрөгийн төлбөрийг өглөгөөр бүртгээгүй.	1	132,976.5	1	132,976.5						
7	Аймгийн төвийн хог хаягдлыг бууруулах ажлын гүйцэтгэлийн дутуу 1,128.6 мянган төгрөгийн төлбөрийг өглөгөөр бүртгээгүй.	1	1,128.6	1	1,128.6						
8	Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгч нарт хүндэтгэл үзүүлэхдээ Аймгийн ИТХ-аас баталсан бэлэг дурсгалын зүйл гардуулах зардлын нормативаас 978.0 мянган төгрөгийг илүү олгосон.	1	978.0			1	978.0				

9	Аудитаар санхүүгийн тайлан дахь өндөр насжилттай 16,289.1 мянган төгрөгийн өр төлбөр, авлагын үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй, барагдуулах арга хэмжээ аваагүй.	1	16,289.1					1	16,289.10		
10	Аудитаар зочид төлөөлөгчдөд өгөх бэлэг буюу 14,091,200 төгрөгийн бараа материалыг шууд зардлаар тайлагнаж, хяналтгүй зарцуулсан.	1	14,091.2					1	14,091.2		
11	Аймгийн ЗДТГ албан хаагчдын нийгмийн баталгааг хангах дэмжлэг олгохдоо, тодорхой шалгуургүй, цаашид тогтвор сууршилтай ажиллуулах талаар гэрээ байгуулалгүй дэмжлэг үзүүлсэн	1								1	
	Дүн	11.0	650,195.9	7.0	618,837.6	1.0	978.0	2.0	30,380.3	1.0	0.0
	Нийт дүн	12.0	664,868.1	7.0	618,837.6	1.0	978.0	3.0	45,052.5	1.0	0.0